

**“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2025 оны 03 сарын 14-ний өдөр

№ 26/2025

Улаанбаатар хот

**Компанийн хувьцааг эргүүлэн худалдан авч,
халааслах тухай**

Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 49.2, 49.4, болон 49.5, 55 дугаар зүйлийн 55.2 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.7 дахь заалт, “Түмэн шувуут” нээлттэй Хувьцаат Компани (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.15 дахь заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, хувьцааны ханшийг тогтворжуулах, хөрөнгө оруулагчийн эзэмшиж буй хөрөнгийн үнэ цэнийг өсгөх, эрх ашгийг нь хамгаалах зорилгоор нийт 1,000,000,000 /Нэг тэрбум/ төгрөг хүртэлх үнийн дүнгээр “Түмэн шувуут” ХК-ийн хувьцааг энэхүү тогтоолын Нэгдүгээр хавсралтад заасан нөхцлийн дагуу Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтээс эргүүлэн худалдан авч, халааслахаар шийдвэрлэсүгэй.
2. “Түмэн шувуут Хувьцаат компанийн хувьцааг эргүүлэн худалдан авч, халааслах журам”-ыг энэхүү тогтоолын Хоёрдугаар хавсралтаар баталсугай.
3. Хувьцааг эргүүлэн худалдан авах ажиллагаатай холбоотой гэрээ хэлцэл болон холбогдох баримт бичигт компанийг төлөөлөн гарын үсэг зурах, хувьцааг хууль тогтоомжийн дагуу худалдан авах, төлбөр тооцоо хийж, бүртгэл тайлагналыг цаг тухай бүрт нь мэдээлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Ж.Болд/- д даалгасугай.
4. Санхүүгийн зохицуулах хороо, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв болон Монголын хөрөнгийн биржтэй харилцан хамтран ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ж.Болд/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.ЭРХЭМБАЯР

“Түмэн шувуут” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2025 оны 03 сарын 14-ны өдрийн 06 дугаар
тогтоолын Нэгдүгээр хавсралт



“ТҮМЭН ШУВУУТ” ХК-ИЙН ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВАХ, ХАЛААСЛАХ НӨХЦӨЛ		
1	Хувьцааг эргүүлэн худалдан авах захиалгын дээд үнэ	Өмнөх 30 хоногийн Хөрөнгийн биржийн арилжааны жигнэсэн дундаж ханшийн 120 (нэг зуун хорь) хувиас хэтрэхгүй
2	Нэг сард эргүүлэн худалдан авах дүн /төгрөг/	200,000,000 (хоёр зуун сая) төгрөгөөс хүртэл
3	Эргүүлэн худалдан авах нийт үнийн дүн /төгрөг//	1,000,000,000 (нэг тэрбум) төгрөг хүртэл
4	Хувьцааг эргүүлэн худалдан авах хугацаа	2025 оны 05 сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 сарын 31-ний өдрийг дуустал
5	Мэдээлэл түгээх	Долоо хоног тутмын Баасан гаригт тухайн 7 хоногт халаасалсан хувьцааны тоо, дундаж ханшийн талаарх мэдээллийг компанийн www.tumenshuvuut.mn болон хөрөнгийн биржийн www.mse.mn цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

“Түмэн шувуут” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2025 оны 03 сарын 14-ны өдрийн 06 тоот
тогтоолын Хоёрдугаар хавсралт



“ТҮМЭН ШУВУУТ” ХК-ИЙН ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВЧ, ХАЛААСЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмаар “Түмэн шувуут” ХК (цаашид “компани” гэх) Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтээс компанийхаа хувьцааг эргүүлэн худалдан авч, халааслах ажиллагааг зохицуулна.

Хоёр. Журмын зорилго

- 2.1 “Түмэн шувуут” ХК-иас олон нийтэд санал болгож гаргасан хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, хувьцааны ханшийг тогтворжуулах, хөрөнгө оруулагчийн эзэмшиж буй хөрөнгийн үнэ цэнийг өсгөх, эрх ашгийг нь хамгаалахад оршино.

Гурав. Үйлчлэх хүрээ

- 3.1 Энэхүү журам нь Монголын Хөрөнгийн бирж дээр нээлттэй арилжаалагдаж буй “Түмэн шувуут” ХК-ийн хувьцааг эргүүлэн худалдаж авах үйл ажиллагаанд үйлчилнэ.

Дөрөв. Хувьцааг эргүүлэн худалдаж авах нөхцөл

- 4.1 Эргүүлэн худалдаж авах үйл ажиллагааг дараах хязгаарын хүрээнд явуулна.
- 4.1.1 Хувьцааг эргүүлэн худалдан авах захиалгын дээд үнэ нь өмнөх 30 хоногийн Хөрөнгийн биржийн арилжааны жигнэсэн дундаж ханшийн 120 (нэг зуун хорь) хувиас хэтрэхгүй
 - 4.1.2 Нэг сард эргүүлэн худалдан авах дүн нь 200,000,000 (хоёр зуун сая) төгрөгөөс хэтрэхгүй.
 - 4.1.3 Эргүүлэн худалдан авах нийт үнийн дүн 1,000,000,000 (нэг тэрбум) төгрөг хүртэл байна.
- 4.2 Хувьцааг эргүүлэн худалдан авах үйл ажиллагааг 2025 оны 05 сарын 01 -ний өдрөөс 2025 оны 12 сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд гүйцэтгэнэ.
- 4.3 Эргүүлэн худалдан авах хувьцааны нийт үнийн дүнгээр 100 хувь хувьцаа худалдан авахгүй байж болно.
- 4.4 Эргүүлэн худалдаж авах хувьцааны төлбөрийг төгрөгөөр гүйцэтгэнэ.

Тав. Хувьцааг эргүүлэн худалдаж авах үйл ажиллагаанд оролцогчийн бүрэн эрх

- 5.1 Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (“ТУЗ”) дараах бүрэн эрхтэй.
- 5.1.1 Энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулах
 - 5.1.2 Энэхүү журмын дагуу эргүүлэн худалдаж авсан компанийн халаасны хувьцааг буцаан гүйлгээнд оруулах асуудлыг шийдвэрлэх
 - 5.1.3 Хувьцааг эргүүлэн худалдаж авах асуудлаар хяналт тавих, асуулт тавих, зөвлөмж гаргах, үүрэг даалгавар өгөх, зогсоох
- 5.2 Компанийн Гүйцэтгэх захирал нь хувьцааг эргүүлэн худалдаж авахтай холбоотой дараах бүрэн эрхтэй.
- 5.2.1 Хувьцааг худалдаж авах ажиллагааг ТУЗ-өөс олгосон бүрэн эрх, энэхүү журамд заасан хүрээнд удирдан зохион байгуулах
 - 5.2.2 Энэхүү журмын хэрэгжилт, эргүүлэн худалдаж авсан хувьцааны талаарх мэдээллийг тухай бүр ТУЗ-д тайлагнах
 - 5.2.3 Компани нь хувьцааг эргүүлэн худалдаж авах ажиллагаанд аливаа ашиг сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлэх
 - 5.2.4 Хувьцааг эргүүлэн худалдаж авахтай холбоотой аливаа гэрээ хэлцэл байгуулах
 - 5.2.5 Хувьцааг эргүүлэн худалдаж авахтай холбоотой мэдээллийг олон нийтэд болон эрх бүхий этгээдэд мэдэгдэх, мэдээлэх, компанийн хувьцаа эзэмшигчдэд заавар зөвлөгөө өгөх

Зургаа. Хүчин төгөлдөр болох хугацаа

- 6.1 Энэхүү журам нь батлагдсан өдрөөсөө хүчин төгөлдөр болно.